

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн зохицуулалт:
сайжруулах зарим асуудал**

Мэндбаярын Долгорсүрэн

Магистр

Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн

Улаанбаатар, Монгол Улс

angelnice999888@gmail.com

Хураангуй

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зохицуулалт болон олон улсын жишгийг харьцуулан судалж, түүний эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал дэвшүүлэхийг зорилоо.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн институт нь манай төрийн эрх мэдлийн байгууллагуудын тогтолцоонд өвөрмөц байр суурийг эзэлдэг боловч юуны өмнө Үндсэн хуульд Ерөнхийлөгчийн институт төрийн эрх мэдлийн аль салбарт хамаарахыг зохицуулаагүй нээлттэй орхисон нь анхаарал татаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн зохицуулалтаас харахад Ерөнхийлөгч төрийн эрх мэдлийн аль ч салбарт хамаарахгүй байдалтай байдаг. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно” гэж өөрчилсөн. Энэ өөрчлөлт нь Ерөнхийлөгчийн тодорхой бүрэн эрх нь зөвхөн Үндсэн хуулиар олгосон үндсэн бүрэн эрхийн хүрээнд байх, үндсэн бүрэн эрхээс давсан тодорхой бүрэн эрхийг шинээр олгохгүй байх агуулгатай болох нь харагдаж байна. Иймд Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан агуулгад нийцүүлж, Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхийн нэгдмэл байдлыг хангаж, Ерөнхийлөгчийн “бусад тодорхой бүрэн эрх”-ийг Үндсэн хуульд заасан үндсэн бүрэн эрхийн хүрээнд байх агуулгаар тодорхойлох шаардлагатай байна.

Түлхүүр үгс: *эрх зүйн орчин, эрх зүйн баримт бичиг, олон улсын жишиг, төгөлдөржүүлэлт, эрх зүйн байдал*

Legal regulation of the President of Mongolia: some issues for improvement

Dolgorsuren Mendbayar

Master of Arts

Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences

Ulaanbaatar, Mongolia

angelnice999888@gmail.com

Abstract:

In this academic article, we aim to compare the regulation of the rights of the President of Mongolia and international standards, and propose proposals for improving its legal environment. The institution of the President of Mongolia occupies a unique position in the system of our state power institutions, but first of all, it is noteworthy that the Constitution leaves it open as to which branch of the state power the institution of the President belongs to. According to the provisions of Article 3, Section 3.2 of the Law on the President of Mongolia, the President does not belong to any branch of state power.

According to the amendments to the Constitution of 2019, Section 4 of the Thirty-third Article was changed to “The President may be granted certain mandates by law only within the scope specified in this Article.” It can be seen that this change has the content that specific powers of the President are only within the framework of the basic powers provided by the Constitution, and no new specific powers beyond the basic powers will be granted. Therefore, it is necessary to clarify the “other specific powers” of the President in the context of the basic powers stipulated in the Constitution, in order to comply with the content specified in Section 4 of the Thirty-third Article of the Constitution and to ensure the unity of the basic powers of the President.

Keywords: *legal framework, legal documents, international standards, perfection, legal status*

I. Оршил

Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зохицуулалт болон олон улсын жишгийг харьцуулан судалж, түүний эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал дэвшүүлэхийг зорилоо.

Нийгэмд иргэддээ хүчтэй сэтгэгдэл төрүүлдэг, тэдний бэлгэдэл нь болж байдаг төрийн болон нийгмийн янз бүрийн албан тушаал хэргэм байдаг. АНУ-д бол энэ нь Ерөнхийлөгч, Японд бол эзэн хаан болно. АНУ-ын Ерөнхийлөгч бол улс орны албан ёсны тэргүүн төдий биш, харин үндэсний эв нэгдэл, уламжлал, үнэт зүйлсийн бэлгэдэл байдаг. Эндээс эрдэмтэн Т.Уайттын ажигласан “*иргэд Ерөнхийлөгчөөрөө хамгийн сайн хүнээ сонгодог*” гэсэн домог үүсдэг. Т.Уайттын үзэж байгаагаар энэ домгоос “*албан тасалгаа нь ямар ч эзнийг чимж байдаг*” гэсэн өөр нэг дүгнэлт гарах юм. Ийм маягаар легитим эрх мэдэл нь хувийн эрх мэдлийг бүтээж байдаг (Д.Ганхуяг 2004, 90).

Монгол Улс бол парламентын засаглалтай. 1992 онд баталсан Үндсэн хуульд Монгол Улсад Ерөнхийлөгчийн институт байхаар хуульчилсан билээ. 1993 оноос хойш 8 удаа Монгол Улсын иргэд Ерөнхийлөгчөө бүх нийтээрээ сонгосон байна. Ерөнхийлөгчийг бүх ард түмнээс сонгож, төрийн тэргүүн хэмээн үздэг. Ерөнхийлөгч бол Монгол Улсын төрийн тэргүүн, үндэсний эв нэгдлийг илэрхийлэгч, тэргүүн дипломат, үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн, зэвсэгт хүчний ерөнхий командлагч юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн институт нь манай төрийн эрх мэдлийн байгууллагуудын тогтолцоонд өвөрмөц байр суурийг эзэлдэг боловч юуны өмнө Үндсэн хуульд Ерөнхийлөгчийн институт төрийн эрх мэдлийн аль салбарт хамаарахыг зохицуулаагүй нээлттэй орхисон нь анхаарал татаж байна. Төр судлалд Ерөнхийлөгчийг ихэвчлэн гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд хамааруулж үздэг. “*Монгол Улсын Ерөнхийлөгч төрийн тэргүүний хувьд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах ашиг сонирхлын үүднээс хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллагууд зүй зохистой харилцан ажиллахад нь Үндсэн хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дэмжлэг нөлөө үзүүлнэ*” гэсэн хуулийн заалтыг үзвэл төрийн эрх мэдлийн аль ч салбарт хамаарахгүй байдалтай байдаг. Ялангуяа Парламентын Бүгд Найрамдах Улсуудад болон засаглалын аль ч хэлбэрийн нөхцөлд төрийн тэргүүн гүйцэтгэх эрх мэдэлд илүү ойр байдгийг иш үндэс болгон гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд Ерөнхийлөгчийн статусыг авч үзэх нь цөөнгүй байна.

Бүгд Найрамдах төрийн холимог тогтолцоо улс төр судлаач Maurice Duverger 1978 онд Францын 5 дахь Бүгд Найрамдах Улсыг «*semi presidential*» буюу холимог тогтолцоотой гэж нэрлэснээр энэ нэр томъёог хэрэглэх болсон байна (Д.Гангабаатар 2016, 232). Холимог тогтолцоо нь ихэвчлэн Засгийн газар, Ерөнхийлөгч нь гүйцэтгэх засаглалын эрх мэдлийг хувааж хэрэгжүүлдэг. Түүнчлэн төрийн тэргүүн нь ард түмнээс шууд сонгогддог ба гадаад харилцааны зарим салбарыг Ерөнхийлөгч тэргүүлэхээр заасан (Д.Гангабаатар 2016, 233) зэрэг үндсэн шинжүүдээс үзвэл Монгол Улсын Ерөнхийлөгч энэ шинжийг агуулж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд Ч.Энхбаатарын “*Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдал: Үндсэн хуулийн зохицуулалт ба өнөөгийн практик*” (Хууль дээдлэх ёс. Уб., 2012. №1/36); Я.Төгөлдөрийн “*Монгол Улсын төрийн тогтолцоо дахь Ерөнхийлөгчийн институтийн байр суурь эрх мэдлийн хэрэгжилтийн шинжилгээ*” Монгол Улсын Төрийн байгуулал дахь засаглалын институтын талаарх судалгааны эмхэтгэл (Уб., 2018); Удирдлагын академийн “*Монгол Улсын төрийн тогтолцоо дахь Ерөнхийлөгчийн байр суурь, бүрэн эрхийн шинжилгээ*” Судалгааны тайлан (Уб.,2019); ХЗҮХ “*Ерөнхийлөгчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ*” Судалгааны тайлан (Уб.,2021); “*Монгол Улсын Үндсэн хууль дахь Ерөнхийлөгчийн институтийн зарим нэр томъёо*” судалгаа. (Уб.,2020) Хууль зүйн үндэсний хүрээлэн. Монгол Улсын Ерөнхийлөгчид бүрэн эрх олгосон холбогдох хуулийн зохицуулалтын судалгаа (Уб.,2021) зэрэг бүтээлүүдэд хэсэгчилсэн байдлаар судалгаа хийсэн болно.

Төрийн эрх мэдлийн хуваарилалтыг илүү тодорхой болгох, үндэсний эв нэгдлийг бататгах үүднээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн зохицуулалтыг сонгодог парламентын тогтолцоотой орнуудын жишигт нийцүүлэх, төрийн тогтолцоонд түүний эзлэх байр суурийг нь төгөлдөржүүлэх зарим шаардлага байна.

Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан агуулгад нийцүүлж, Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхийн нэгдмэл байдлыг хангаж, Ерөнхийлөгчийн “*бусад тодорхой бүрэн эрх*”-ийг Үндсэн хуульд заасан үндсэн бүрэн эрхийн хүрээнд байх агуулгаар тодорхойлох шаардлагатай байна.

Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн талаар Академич Ж.Амарсанаа “Ардчилсан эрх зүйт ёс” номдоо одоо байгаа тогтолцоог төгөлдөржүүлэн хөгжүүлэх үүднээс бүрэн эрхийн талаар хэлэхдээ: “*Ерөнхийлөгчийн институт нь түүний бүрэн эрх гэсэн ойлголттой салж болохгүй ойлголт. Ерөнхийлөгчийг жинхэнэ утгаар нь ойлгох хэрэгтэй бол түүний бүрэн эрх гэж юу болох, бүрэн эрхийг “төгс” (харьцангуй утгаар) бий болгохын тулд хууль тогтоомжийн зүгээс ямар нэг алхам хийх талаар ярилцах нь зүйтэй*” (Ж.Амарсанаа 2009, 48) гэжээ.

Дэлхийн улс орнуудын хувьд Ерөнхийлөгч ямар бүрэн эрх эдэлж байгаагаас хамааран тухайн улсын засаглалын хэлбэрийг харж болдог байна. Улс орон бүр өөрийн онцлогоос хамааран Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг ялгаатай зохицуулсан шиг манай улсын хувьд ч өөрийн орны онцлог, уламжлал, шинэчлэлийг шингээсэн хэв шинж бүхий Ерөнхийлөгчдөө бүрэн эрхийг олгосон явдал юм.

II. Судалгааны арга зүй

Баримт бичгийн судалгаа: Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллийг гүйцэтгэхдээ үндэсний болон олон улсын эрх зүйн баримт бичгийн шинжилгээ, агуулгын шинжилгээ, ажиглалтын арга зүй болон социологийн тоон болон чанарын судалгааны арга, мөн судалгааны харьцуулалтын болон задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг аргуудыг ашигласан.

III. Хэлэлцүүлэг

Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах зарим асуудлыг нарийвчлан судалж, сэдэвтэй холбогдох судалгаагаар өгүүллээ баяжуулсан. Өгүүллийн сэдвийн хүрээнд Ерөнхийлөгч нараас санаачилсан хуулийн төслүүдийн судалгаа, Ерөнхийлөгчөөс Засгийн газарт чиглэл өгсөн зарлигуудын судалгаа, Ерөнхийлөгчийн хэм хэмжээ тогтоосон зарлигуудын судалгаа, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн дүн шинжилгээ зэрэг судалгаануудаар өгүүллээ илүү нарийвчлан баяжуулж, тодорхой болгосон. Иймээс цаашид Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг нарийвчилсан судалгааг тогтмол, үр нөлөөтэй, явуулах шаардлагатай хэмээн үзэж дараахь байдлаар үндсэн хэлэлцүүлгийн саналыг өрнүүлж байна.

Франц орны хувьд төрийн байгууламжийн хувьд Монгол Улсын Ерөнхийлөгчийн статустай ижил байгааг сонгон харьцуулан авч үзэхдээ харьцуулалтын аргыг хэрэглэсэн. Ерөнхийлөгч нараас санаачилсан хуулийн төслүүдийн судалгаа, Ерөнхийлөгчөөс Засгийн газарт чиглэл өгсөн зарлигуудын

судалгаа, Ерөнхийлөгчийн хэм хэмжээ тогтоосон зарлигуудын судалгаа, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн дүн шинжилгээнд социологийн тоон судалгааны аргыг хэрэглэсэн. Ерөнхийлөгчийн эрх мэдэлтэй холбоотой тодорхой тохиолдол дээр социологийн чанарын судалгааны шинжилгээ хэрэглэсэн. Судалгаанд холбогдох статистик мэдээлэл, одоо хэрэгжиж буй эрх зүйн зохицуулалт, эрх зүйн шинжилгээ хийж өгүүллийн холбогдох хэсгүүдэд ашиглав.

Монгол Улсын хувьд Үндсэн хуульдаа парламентын засаглалтай эрх мэдэлтэй Ерөнхийлөгчтэй байхаар зохицуулсан (Н.Лүндэндорж 2010, 190). Үүнээс үзвэл Монгол Улсын Ерөнхийлөгч нь онцгой нөхцөл байдлын үед шийдвэр гаргаж болох нь харагдаж байна. Энэ өндөр албыг “*бэлгэ тэмдгийн шинжтэй*” гэх нь бий ч Үндсэн хуулиар Ерөнхийлөгчид цөөнгүй эрх олгосон байдаг.

1992 оны Монгол Улсын ардчилсан Үндсэн хуульд Парламентын засаглалыг хуульчлан тогтоохдоо хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллагууд зүй зохистой харилцан ажиллахад нь дэмжлэг үзүүлэх үндсэн болон тодорхой бүрэн эрхээр хангагдсан төрийн тэргүүн - Ерөнхийлөгчтэй байхаар хуульчилсан.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхийг органик хууль болон бусад хуулиар тодорхой болгох шаардлага үүсэхийг үгүйсгэх аргагүй ч, энэ нь Үндсэн хуульд заасан үндсэн бүрэн эрхийн хүрээнд байх шаардлагыг хангах ёстой. Энэ талаар Б.Чимид “*Тодорхой бүрэн эрх нь үндсэн бүрэн эрхийн хүрээнд түүний хууль зүйн хувьд нарийвчлан журамласан (процедурчилсан) амьдралын тодорхой нөхцөл байдал (гепотези)-д уг бүрэн эрхийг хэрэгжүүлэх механизмыг тодорхойлж үйлдэл, арга замаар (диспозици-ээр) дэлгэрүүлсэн байдаг*” (Б.Чимид 2008, 152) гэжээ. Түүнчлэн УИХ-ын 1993 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн танилцуулгын талаарх чуулганы протоколд “*Үндсэн хуулийн 33-р зүйлд заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг тодотгох, үндсэн бүрийн эрхийн хүрээнд тодорхой бүрэн эрхийг тусгах замаар Ерөнхийлөгчийн эдлэх бүрэн эрхийг зохих чиглэлүүдээр зүйлчлэн тусгаж байна*” гэж тэмдэглэсэн байна (ЕТГ 1993, 8).

2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “*Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно*” гэж өөрчилсөн. Энэ өөрчлөлт нь Ерөнхийлөгчийн тодорхой бүрэн эрх нь зөвхөн Үндсэн хуулиар олгосон үндсэн бүрэн эрхийн хүрээнд байх, үндсэн бүрэн эрхээс давсан тодорхой бүрэн эрхийг шинээр олгохгүй байх агуулгатай болох нь харагдаж байна. Иймд Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан агуулгад нийцүүлж, Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхийн нэгдмэл байдлыг хангах үүднээс Ерөнхийлөгчийн “*бусад тодорхой бүрэн эрх*”-ийг Үндсэн хуульд заасан үндсэн бүрэн эрхийн хүрээнд байх агуулгаар тодруулах шаардлагатай байна. Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нийт 65 (ХЗҮХ 2021) хуульд Ерөнхийлөгчийн бүрэн эрхтэй холбоотой зохицуулалт агуулагдаж байна. Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр Гучин гуравдугаар зүйлийн 4-т “*Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно*” гэж үндсэн бүрэн эрхэд хамаарах эрхээр хязгаарласан бол МУЕтХ-иар 15 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “*Ерөнхийлөгчид бусад тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно*”

гэсэн нь Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэт нэмэгдүүлсэн, дурын хуулиар бүрэн эрх олгож болох зохицуулалт байгаа юм.

Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрх нь Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1-д заасан 12 заалт (Монгол Улсын Үндсэн хууль 1992) бөгөөд эдгээрээс дийлэнх олонх буюу нийт 9 бүрэн эрх нь гүйцэтгэх засаглалын хүрээнд хэрэгжиж байна. Үлдсэн бүрэн эрх нь УИХ болон Шүүх эрх мэдэлтэй харилцахтай холбоотой эрх хэмжээ болж байна (Я.Төгөлдөр. 2018, 39). Харин тодорхой бүрэн эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 4-т зааснаар “*Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгоно*” гэсэн заалтын дагуу нийт 40 орчим^{2*} салбар хуульд Ерөнхийлөгчийн тодорхой бүрэн эрхийг хуульчилж өгсөн байна.

Ерөнхийлөгч Үндсэн хуулиар олгосон үндсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах тодорхой бүрэн эрх олгох талаар саналаа УИХ-д өргөн мэдүүлж болох эрхтэйг хуульчилжээ. Ерөнхийлөгчийн эрхийг ямар нэгэн байдлаар тодотгон өргөтгөсөн заалтууд 30 гаруй хуульд тусгагдан оржээ. Эдгээрийн ихэнх нь тодорхой албан тушаалд томилохоор санал болгосон хүнийг зөвшилцсөний үндсэн дээр Парламентад санал болгох буюу батламжлах байдлаар томилох, мэдээлэл сонсох, санал, дүгнэлтээ хэлэх, бэлгэдэл, зэрэг дэвийн асуудлыг шийдвэрлэх, дүрэм, журам тогтоох зэрэгтэй холбоотой харилцаанууд байна (УТБА 2021, 29). Ерөнхийлөгчийн тодорхой бүрэн эрх үндсэн бүрэн эрхээсээ хэд дахин өргөн хүрээтэй, төрийн байгууллагуудтай харилцахдаа холбоотой 70 орчим эрх, 40 орчим хуулийн зүйл, заалтаар зохицуулагдаж байна. Тухайлбал, 2010 оноос хойш шинэчилсэн найруулгаар батлагдсан хуулиудад Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхтэй холбогдох зүйл, заалтуудыг түүвэрлэн үзэхэд нийт 19 хуульд 50 гаруй заалтаар Ерөнхийлөгчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг нарийвчлан тодорхойлсон байна. Судлаачдын үзэж байгаагаар өнгөрсөн хугацаанд жил ирэх бүр Ерөнхийлөгчийн чиг үүрэг нэмэгдэж, эрх мэдэл “*данхайж*” ирсэн. Ерөнхийлөгч гүйцэтгэх болон шүүх эрх мэдэлд хэт оролцож, эрх мэдлийн тэнцвэрийг алдагдуулж ирсэн гэх нийтлэг дүгнэлтийн дагуу Ерөнхийлөгчийн эрх мэдэлд холбогдох шинэ зохицуулалтууд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгалаа олсон юм. Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хязгаарлах бөгөөд Ерөнхийлөгчид Монгол Улсын Үндсэн хуульд заасан үндсэн бүрэн эрхийн хүрээнд үл хамаарах бүрэн эрхийг хуулиар олгохгүй хэмээн тусгажээ. Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 4-т “*Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно*” гэсэн заалт байсныг Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр “*Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно*” хэмээн өөрчлөн найруулсан нь чухал ач холбогдол бүхий зохицуулалт болсон. Ингэснээр Үндсэн хуулиас бусад хуулиудаар Ерөнхийлөгчид өөр эрхүүдийг нэмж олгодог байсан явдлыг эцэс болгохыг зорьсон байна. Хэдийгээр Үндсэн хуульд заагаагүй бусад эрх мэдлийг хэрэгжүүлэх бололцоо нь хаагдсан ч Ерөнхийлөгчид хууль санаачлах гэсэн чухал эрх хадгалагдан үлдсэн. Судлаачдын хэлж байгаагаар, парламентын засаглалтай улсуудад Ерөнхийлөгч нь хууль санаачилдаггүй, хагас Ерөнхийлөгчийн засаглалтай

^{2*} Эдгээр тодорхой бүрэн эрхийн талаар тусгасан холбогдох хуулийн зохицуулалтыг хавсралт 4-өөс дэлгэрүүлэн үзнэ үү.

улсуудад ч Ерөнхийлөгч хууль санаачлах нь тун ховор байдаг. Засгийн газар бодлогоо хэрэгжүүлэх гэтэл ард түмнээс сонгогдсон Ерөнхийлөгч сонгуульд нэр дэвшихдээ амлалт өгч, түүндээ тулгуурлан хуулиуд санаачилж, улмаар хоорондоо бодлогын мөргөлдөөн үүсгэх тохиолдол цөөнгүй гардаг. Хууль санаачлах хүрээнд өмнөх Ерөнхийлөгчдийн гаргасан сайн санаачилгын жишээ ч байгаа. Тухайлбал, анхны Ерөнхийлөгчийн санаачилсан “Алт хөтөлбөр” тухайн үеийн эдийн засагт чухал нөлөө үзүүлсэн, дөрөв дэх Ерөнхийлөгчийн санаачилсан Шилэн дансны тухай хууль өдгөө засаглалын ил тод байдлыг нэмэгдүүлэхэд томоохон түлхэц болсон зэрэг цөөнгүй жишээ байна.

“Ерөнхийлөгч Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгчийн хувьд үндэсний эв нэгдлийн ашиг сонирхлыг дээдэлж, шаардлагатай үед нийгмийн бүлэг, улс төрийн хүчнүүдийн хооронд зөвшилцөлд хүрэхэд нь дэмжлэг үзүүлнэ” хэмээн түүнийг үүргийг тодорхойлсон. Иймд Монгол Улсын Ерөнхийлөгчийн статусын хувьд бэлгэдлийн чанартай сул шинжтэй бус харин ч улс төрийн тогтвортой байдал, нийгмийн эрчимтэй хөгжлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэх институт болох нь харагдаж байна. Ялангуяа өнөөдөр манай нийгэмд бий болоод байгаа улс төрийн төдий ойлгомжтой бус байдал, олон нийтийн зүгээс эрх баригчдын үйл ажиллагааг янз бүрээр ойлгож, тайлбарлаж байгаа нөхцөлд Монгол Улсын Ерөнхийлөгчийн институт төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа байгууллагуудыг үйл ажиллагааны зохистой байдлыг хангахад чухал үүрэгтэй оролцох эрх, үүрэгтэй болох нь тодорхой байна.

Ерөнхийлөгчийн тухай хуульд зааснаар Ерөнхийлөгч төрийн тэргүүний хувьд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах, ашиг сонирхлын үүднээс хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллагууд зүй зохистой харилцан ажиллахад нь Үндсэн хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дэмжлэг нөлөө үзүүлнэ. Ерөнхийлөгч нь Засгийн газартай үр дүнтэй хамтарч ажиллах боломжтой нь эндээс харагдаж байна. Засгийн газартай эрх мэдэл булаалддаг биш харилцан ойлголцсон, нэг нэгнээ нөхсөн хамтын ажиллагааг Ерөнхийлөгчөөс иргэд олон нийт хүлээдэг.

Ерөнхийлөгчийн тухай хуульд үндэсний эв нэгдлийн ашиг сонирхлыг дээдэлж, шаардлагатай үед нийгмийн бүлэг, хэсэг, улс төрийн хүчнүүдийн хооронд зөвшилцөлд хүрэхэд нь дэмжлэг үзүүлдэг. Үндсэн хуультай холбоотой зөрчил гарах, ямар нэг шалтгаанаар Засгийн газрыг байгуулж чадахгүй удах, улс оронд эмх замбараагүй байдал үүссэнээс, улс төрийн намуудын нэгдмэл байр суурь, зөвшилцлийг бий болгох шаардлага гарч болно. Ийм тохиолдлуудад Ерөнхийлөгч ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч байх үүргийн хүрээнд явуулах үйл ажиллагаа ач холбогдолтой болдог (Konrad Adenauer stiftung 2022, 47).

Ерөнхийлөгчийн төрийн эрх мэдлийн салбаруудын үйл ажиллагааны уялдааг хангахад дэмжлэг үзүүлэх болон улс төрийн зөвшилцөл, итгэлцлийг бий болгоход санаачлагч, хошуучлагч байх үүрэг нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудалд Засгийн газарт чиглэл өгөхөөс илүү оролцдоггүй байхыг шаарддаг бөгөөд энэ нь Ерөнхийлөгч хуулийн хүрээнд байх ёстойг илэрхийлж байна. Засгийн газарт чиглэл өгөх тухай Ерөнхийлөгчийн зарлигт Ерөнхий сайд хүлээн зөвшөөрч гарын үсэг зурснаар зарлиг хүчин төгөлдөр болдог. Ийм зохицуулалт Парламентын

Бүгд Найрамдах Улс хэмээн нэрлэдэг төрийн хэлбэр бүхий орнуудад түгээмэл байдаг ба түүнийг давхар гарын үсгийн зарчим гэдэг. Энэ зарчмын улс төрийн агуулга нь Ерөнхийлөгчийн зохицуулагч, эв нэгдлийг илэрхийлэгчийн байр суурийг хамгаалах, чиглэлд заасан үйл ажиллагааны төлөөх хариуцлагыг Засгийн газарт оногдуулж байгаа хэрэг юм. Ерөнхийлөгч сонгогдсоныхоо дараа намын харьяаллаас түдгэлздэг нь мөн ийм агуулгатай.

Ерөнхийлөгчид Үндсэн хуулиар олгосон чухал эрх бол хууль тогтооход оролцохтой холбоотой эрхүүд юм (Конрад Аденауерын сан 2022). Ерөнхийлөгч УИХ-ын чуулганд тааллаараа оролцох ба УИХ болон ард түмэндээ хандан илгээлт гаргана. Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ асуудлаар зарлиг, захирамж гаргадаг. Эрх зүйн хэм хэмжээ тогтоосон, нийтээр дагаж мөрдөх зарлиг нь түүнд өөрөөр заагаагүй бол төрийн төв хэвлэлд албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа, бусад зарлиг, захирамж тэдгээрт өөрөөр заагаагүй бол гарсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно. Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол Ерөнхийлөгч өөрөө буюу УИХ хүчингүй болгоно. Ерөнхийлөгч УИХ-д ажлаа хариуцаж жил тутам үйл ажиллагааныхаа талаар танилцуулна.

Ерөнхий сайдыг томилох санал, Засгийн газрыг бүрдүүлэх болон түүнд өөрчлөлт оруулах асуудлаар Ерөнхийлөгчтэй зөвшилцөхөд тодорхой хугацаа зааж өгсөн нь төрийн үйл ажиллагааг удаашруулж “гацаанд” оруулахгүй байх сайн талтай ч, хуульчилсан хугацаа нь “өнгөрвөл” аль эсхүл ямар нэгэн шалтгааны улмаас зөвшилцөж чадаагүй тохиолдолд Ерөнхийлөгчийн саналыг “үл харгалзан” олонхоороо асуудлыг шийдэж энэ нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллагууд зүй зохистой харилцан ажиллахад нь дэмжлэг үзүүлэх үндсэн болон тодорхой бүрэн эрхээр хангагдсан төрийн тэргүүн-Ерөнхийлөгчийн үүргийг бууруулсан, “үл хүндэтгэсэн” улмаар төрийн институци хоорондын хуулийн хүрээнд явагдах ёстой харилцаа “алдагдсан” байдалд оруулахад хүргэж байна гэж хэлэх үндэслэлтэй байна. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг УИХ-д өргөн мэдүүлснээс хойш 45 хоногийн дотор УИХ хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч УИХ-ыг тараах шийдвэр гаргах эрхтэй байгаа нь хууль тогтоогчид гүйцэтгэх засаглалаас тавих томоохон хяналтын хэлбэр юм.

Ерөнхийлөгчийн тухай хуульд төрийн байгуулал, улс орны удирдлагын талаар Ерөнхийлөгчийн зарлигийн биелэлтийн талаар Засгийн газрын мэдээллийг сонсох, Засгийн газрын хуралдаанд өөрийн тааллаар оролцож санал бодлоо илэрхийлэх, хууль санаачлагчаас УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар саналаа илэрхийлэх зэрэг эрхийг нэмж олгосон ба УИХ-аас тодорхойлсон Монгол Улсын дотоод, гадаад бодлогод нийцээгүй үйл ажиллагаа явуулсан болон үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг хэрэгжүүлэхгүй байгаа, түүнчлэн Засгийн газарт чиглэл өгөх тухай Ерөнхийлөгчийн зарлигийг Засгийн газар хэрэгжүүлээгүй нь Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд сорилт болсон гэж үзвэл Засгийн газрыг огцруулах саналыг УИХ-д оруулна гэж ямар тохиолдолд Ерөнхийлөгч Засгийн газрыг огцруулах саналыг УИХ-д оруулахыг тодорхойлсон байна.

Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, бусад хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчсөн тухай асуудлыг УИХ-ын нийт гишүүний гуравны нэгээс

доошгүй нь албан ёсоор тавивал Үндсэн хуулийн гучин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу УИХ хэлэлцэж Ерөнхийлөгчийг огцруулах эсэхийг шийдвэрлэнэ.

Гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлөх боломжтойн хувьд олон улсын харилцааны мэдлэг, боловсролтой, төр улсаа төлөөлөхүйц туршлага, нөлөөтэй хүн байх нь Ерөнхийлөгчийн ажлын шаардлага юм. Улсын тэргүүн дипломатын хувиар Ерөнхийлөгч идэвхтэй гадаад бодлого явуулж, улс орны нэр хүндийг өргөх чухал харилцаа холбоог тогтоох, бэхжүүлэх бүрэн боломжтой. Гадаад харилцаанд Монгол Улсыг бүрэн эрхтэй төлөөлөхтэй холбогдсон бүрэн эрхийг зааж, тодорхой асуудлаар өөрийн бие төлөөлөгчийг гадаад улсад түр хугацаагаар томилон ажиллуулах эрхийг Ерөнхийлөгчид нэмж олгожээ.

Монголын төрийн тэргүүн Парламентын бусад улсын төрийн тэргүүнүүдээс илүү хүчтэй байх чиглэлийг баримталсан тул Парламентын Бүгд Найрамдах Улсын төрийн тэргүүн төдийлөн эдлээд байдаггүй хууль санаачлах, Засгийн газарт чиглэл өгөх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх зэрэг бүрэн эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгчид олгожээ (Удирдлагын академи 2019, ix).

Ерөнхийлөгч улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнолыг хамгаалах, нийгэмд дэх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй бөгөөд энэ хүрээнд улсын аюулгүй байдлын зөвлөлийг удирддаг.

Үндсэн хуульд тодорхойлсон Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн дагуу УИХ-ын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавьдаг, Засгийн газрын тэргүүнийг томилуулах буюу Засгийн газрыг огцруулах саналыг УИХ-д оруулдаг, чиглэл өгдөг, үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлдэг, Үндсэн хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхийлөгч УИХ-ыг тараах шийдвэр гаргадаг, мөн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар УДШ-ийн Ерөнхий шүүгч, шүүгчид болон бусад шүүхийн шүүгчдийг томилдог зэргээс үзэхэд манай Ерөнхийлөгч төрийн эрх мэдлийн аль ч байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй нөлөө үзүүлэх эрх зүйн статустай субъект болох нь харагдаж байна.

Ерөнхийлөгчийн эдгээр эрх, үүрэг дотроос нэн чухал нь ард түмний эв нэгдлийг илэрхийлэх үүрэг хариуцлага юм. 2008 оны долоодугаар сарын 1-нд болсон үймээний үеэр тухайн үеийн Ерөнхийлөгч онц байдал зарлах зарлиг гаргасан нь энэ үүргээ биелүүлсэн тод жишээ болсон. Өнөөдрийнх шиг халдварт өвчний аюул нөмөрсөн, эдийн засаг доройтсон онцгой үеүдэд Ерөнхийлөгчийн байр суурь, үг үйлдэл иргэдэд чухал нөлөөтэй гэдэг нь ойлгомжтой. Хэлбэрийн талаасаа уламжилсан гэгдэх боловч чиг үүрэг, дэглэм өөрчлөгдсөнтэй холбоотой агуулгын хувьд шинэчлэгдсэн нь төрийн эрх мэдэл хуваарилах зарчмаар засаг төрийн тогтолцоог бэхжүүлж дэлхийн улсуудын жишгээр томьёологдож, 1993 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиар уламжлан тусгагдсан нь өнөөг хүртэл хэрэгжиж, олон талтай цар хүрээ нь өргөжин тэлсээр Монгол Улсын хэмжээнд холбогдолтой 80 гаруй хуульд тусгалаа олж үйлчилж байгаагаас бүрэн эрх хэмжээг зохицуулсан 70 орчим хууль хүчин төгөлдөр үйлчилж байна (ХЗҮХ 2021, 13).

Олон улсын жишиг: Төрийн тэргүүнээ Ерөнхийлөгч хэмээн нэрлэсэн 82 улс (ХЗҮХ 2020, 191) байна. “Төрийн тэргүүн” гэх нэршил нь голдуу Бүгд Найрамдах Улсын Үндсэн хуульд томъёологдсон (Конрад-Аденауэр-Сан 2018, 41) байна.

Төрийн тэргүүн нь улс орныг тэргүүлэн удирдагч, үндэсний эв нэгдэл, эв санааны илэрхийлэл юм. Ихэнх улс оронд гүйцэтгэх засаглалын тэргүүн, Засгийн газрын кабинетын тэргүүлэгчийг “*Ерөнхий сайд*” хэмээн томъёолж, Ерөнхийлөгчийн гүйцэтгэх үүрэг, эрх мэдэл нь харьцангуй бие даасан институтийн хувиар хөгжиж байна гэж үзэж болох юм.

Засгийн газрын үйл ажиллагаанд Ерөнхийлөгчийн дэмжлэг, оролцоо (presence) (Non-Executive Presidents in Parliamentary Democracies 2020) байх нь олон нийтийн дунд төрийн үйл хэрэг үргэлжилж байхын бэлгэдэл, “*Засгийн газрын тэргүүн - Ерөнхий сайд*”-ыг орлон гүйцэтгэх засаглалыг хүчирхэгжүүлдэг бол Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг харьцуулан судалсан судлаачид тухайлбал, Олег Зазнаев (Zaznaev 2014)*-ийн үзсэнээр Ерөнхийлөгчийн, Парламентын, хагас Ерөнхийлөгчийн, холимог Ерөнхийлөгчийн гэх мэт засаглалын бусад хэлбэр бүхий улс оронд Ерөнхийлөгчийн эрх мэдлийг арван шалгуур үзүүлэлтэд тулгуурлан “*Парламент*”-“*Ерөнхийлөгч*”-ийн институтийн хоорондын эрх мэдлийн харьцааг үнэлсэн.

Энэхүү судалгаанд Ерөнхийлөгчийн бие даасан институт дахь Ерөнхийлөгчийн эрх мэдлийг төрөлжүүлэн ангилахдаа орчин үед дэлхийн улс орнууд төрийн дарангуйллаас ангид байх “*separation of powers*” онолын илэрхийлэл болсон засаглалын гурван мөчирт /*хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглал буюу Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 3.2 дахь заалттай уялдуулсан*/ Үндсэн хуулиар түүнд олгосон эрх мэдэл хэрхэн хамаарагдаж байгааг харгалзсан (2021) төдийгүй Франц орны хувьд төрийн байгууламжийн хувьд ижил байгааг сонгон харьцуулан авч үзлээ.

Бүгд Найрамдах Франц Улс 1958 оноос V Бүгд Найрамдах Франц Улс нь 7 жилийн хугацаагаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх хүчтэй Ерөнхийлөгчийн институтийг байгуулсан. Францын ард түмэн Ерөнхийлөгчийг төрийн бүрэн эрхт байдлын бэлгэдэл, Францын ард түмний оюун санаа, үнэт зүйлийн илэрхийлэл (The European Consortium for Political Research (ECPR) n.d.), Үндсэн хуулиар эрх олгогдон баталгаажсан “*төрийн тэргүүн*” хэмээн хууль санаачлах, бодлогын чиглэлд манлайлан тэргүүлэх, идэвхтэй байр сууринаас хандахыг шаарддаг байна. Сайд нарын хурал, Үндэсний Батлан хамгаалах Зөвлөлийн хурал, Шүүхийн Дээд Зөвлөлийн хурал, Гүйцэтгэх Зөвлөлийн хурлыг даргалах, бүх хууль, гэрээ, Засгийн газрын тогтоол, зарлигт гарын үсэг зурах, элчин сайдыг томилох буюу эгүүлэн татах, гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах зэрэг бэлгэдлийн (Studylecturenotes.com 2021) ёслолын эрх мэдлийг хэрэгжүүлдэг.

Тэрээр ард түмэндээ ханданилгээлт гаргана. Ерөнхийлөгч нь гүйцэтгэх засаглал буюу Засгийн газрын кабинетыг тэргүүлдэггүй. Ерөнхий сайдад захиргааны процесс, улс орны дотоод бодлогыг хэрэгжүүлэх асуудлыг итгэмжилдэг.

Тус улс Европ дахь Ерөнхийлөгчийн институтийн хамгийн урт хөгжлийн түүхтэй орны зэрэгцээ төрийн байгууламжийн хэлбэр нь “*Бүгд Найрамдах Улс*” бөгөөд “*хагас*[23](Presidential Legislative Powers 2021)*Ерөнхийлөгчийн тогтолцоо*”-той улсын төлөөлөл юм. Иймд манай орны адил төрийн байгууламжийн хэлбэр нь “*Бүгд Найрамдах Улс*” бөгөөд “*хагас-Ерөнхийлөгчийн тогтолцоо*”-той улсын төлөөлөл тул сонгон судаллаа.

Монгол Улстай харьцуулахад Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгч нь мөн л ард түмний төлөөлөл, үндэстний эв санааны нэгдлийг илэрхийлэгч, бэлгэдлийн шинжтэй эрх мэдэл хэрэгжүүлдэг юм.

Гүйцэтгэх эрх мэдэл: Франц Улсын Ерөнхийлөгч нь Ерөнхий сайдыг тодорхойгүй хугацаагаар томилж, түүний хүсэлтээр албан тушаалаас нь чөлөөлнө.

Ерөнхий сайдтай зөвлөлдөн сайдуудыг томилж, чөлөөлнө. Бусад улсаас ялгаатай нь тэрээр зөвхөн олонх суудал авсан намын тэргүүнийг Ерөнхий сайдаар ёсчлох үүрэг хүлээдэггүй байна. Тухайлбал: 1986-1988, 1993-1995, 1997-2002 (the local.fr n.d.) онд сөрөг хүчний намаас Ерөнхийлөгч сонгогдож байсан түүхтэй. Гагцхүү Үндэсний ассамблей итгэлийг бүрэн дааж чадна гэсэн итгэл үнэмшил хүлээсэн нэр дэвшигчийг Ерөнхий сайдаар томилох бүрэн эрхтэй. Гүйцэтгэх засаглалын болон армийн ихэнх дээд албан тушаалтныг Ерөнхийлөгч томилно. Тэрээр тус улсын Зэвсэгт хүчний Ерөнхий Командлагч байж, улсын батлан хамгаалах үүрэг хүлээнэ. Засгийн газрын үйл ажиллагаанд түүний эдлэх эрх мэдэл нэн чухал ач холбогдолтой.

Хууль тогтоох эрх мэдэл: Франц Улсын Үндсэн хуулийн 12 дугаар зүйлд Ерөнхийлөгчөөс ямар ч асуудлаар Үндэсний ассамблейг тараах эрх мэдлийг хуульчилсан. Ерөнхийлөгч нь тус заалт ёсоор Ерөнхий сайд, парламентын хоёр танхимын тэргүүнтэй зөвлөлдөн доод танхим буюу Үндэсний ассамблейг тараах эрхтэй. Гэхдээ энэхүү эрхийг эдлэхэд хоёр хязгаарлалт тогтоосон байдаг. Үүнд: нэгд, ерөнхий сонгууль явуулснаас хойш 1 жилийн дотор, хоёрт, үндэсний хэмжээнд онц байдал зарласан үед Үндэсний ассамблейг тараахыг хориглодог байна.

Ерөнхийлөгч нь Парламентын хуралдааныг зарлан хуралдуулах, таслан зогсоох, парламентад илгээлт гаргах, өөрийн нэн чухал гэж үзсэн аливаа асуудлаар Засгийн газрын бус өөрийн байр суурийг илэрхийлэх эрх эдэлнэ. Парламентаас баталсан хуулийг Засгийн газарт шилжүүлснээс хойш 15 хоногийн дотор гарын үсэг зурна. Хэрэв Ерөнхийлөгч хуулийн төслийг парламент дахин нягтлах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэхүү хүсэлтээ хууль тогтоогчид уламжилна. Ийнхүү дахин хянагдсан хуулийн төсөлд дахин татгалзах эрхгүй.

Францын Улсын Ерөнхийлөгч нь нийтийн албаны байгууллагыг байгуулах, соёрхон батлах гэрээ байгуулах гэх мэт Засгийн газраас санаачилсан хуулийн аль ч төсөлд ард нийтийн санал асуулга явуулах эрхтэй. Ард нийтийн санал асуулгаар хуулийн төсөлд нөлөөлөх нь Ерөнхийлөгчөөс^{3*} шууд ардчиллыг төлөвшүүлэх,

³ * V Бүгд Найрамдах Франц Улсын Үндсэн хууль, 11 дүгээр зүйл “The President (at the request of the Government) may submit to a referendum any government bill concerning the organization of public authorities, economic or social policy, public services, or ratification of certain treaties”.

өөрийн хууль санаачлах эрхээ ард түмний дэмжлэгтэйгээр (Presidential Legislative Powers n.d.) шууд хэрэгжүүлэх чухал боломжийг олгодог гэж үздэг. Хэрэв Ерөнхийлөгч ард нийтийн санал асуулгаас хүлээн зөвшөөрсөн дүнг хүлээн авсан бол 15 хоногийн дотор албан ёсоор гарын үсэг зурж ёсчилно.

Шүүх эрх мэдэл: Шүүхийн Дээд Зөвлөлтэй зөвлөлдөн Ерөнхийлөгч нь гэмт хэрэг үйлдсэн этгээдэд уучлал үзүүлэх, ялын гүйцэтгэлийг хойшлуулах, өршөөл үзүүлнэ. Тус зөвлөлийн 9 гишүүнийг Ерөнхийлөгчөөс томилдог. Ийнхүү томилохдоо Үндсэн хуульд заасан ёсоор Ерөнхий сайдтай заавал хамтран гарын үсэг зурсан байхыг шаардана.

Онцгой эрх мэдэл: Үндэсний хэмжээнд онц байдал зарлах үед Ерөнхийлөгчийн эдлэх онцгой бүрэн эрхийн хүрээ, заагийг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд хуульчилсан. Тухайлбал, 1. Бүгд Найрамдах Улсын төрийн байгуулалт, 2. үндэсний тусгаар тогтнол, 3. олон улсад хүлээсэн үүргээ сахин биелүүлж, төрийн дээд байгууллагаас хэвийн үйл ажиллагаа явуулахад ноцтой аюул тулгарсан үед нэн яаралтай авч хэрэгжүүлэх дэг журам сахиулах арга хэмжээг удирдан зохион байгуулах, (*бодлогын манлайлал үзүүлэх, дайны болон улсыг батлан хамгаалах, гадаад бодлого*) Ерөнхийлөгчийн эрх мэдлийг эрс нэмэгдүүлсэн тул чухал ач холбогдолтой эрх мэдэл юм. Тэрээр Ерөнхий сайдтай албан ёсоор зөвлөлдөн “Үндсэн хуулийн Зөвлөл”-ийг хуралдуулах, хуралдааныг даргалах эрхтэй.

Монгол Улсын хувьд Үндсэн хуулийг анхлан боловсруулагчдын хүсэл зоригийг ямагт эрхэмлэн, Ерөнхийлөгчийн ёслол, бэлгэдлийн шинжтэй эрх мэдэл хэрэгжүүлэх Үндсэн хуулийн үзэл санааг ямагт эрэлхийлэх нь зүйтэй юм. Франц орны хувьд хүчирхэг Ерөнхийлөгчийн засаглалыг төлөвшүүлж байгааг дэлхий дахинаа харуулж байгаа нь манай орны хувьд үлгэрлэх гэхээсээ илүүтэйгээр болгоомжлох, нэг хүний гарт эрх мэдлийг хэт төвлөрүүлэн хуульчлахаас зайлсхийхийг ямагт сануулж байх сайн жишиг болно гэж үзэж болох юм.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан 2019 оны нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Ерөнхийлөгчийн хууль санаачлах эрхийн хүрээ хязгаарыг хуулиар тогтоох шаардлагатай гэж үзэн Улсын Их хурлын хуулиар хууль санаачлах эрх бүхий 78 субъект болох УИХ-ын 76 гишүүн, Засгийн газар, Ерөнхийлөгч тус бүрт хүрээ хязгаар тогтоосон. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38.2 дахь хэсэгт Ерөнхийлөгч эдгээрээс бусад хүрээнд Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсгийг баримтлан хууль санаачлах талаар зохицуулсан байна. /Энэ зүйлийг 2020 оны 11 дүгээр сард өөрчлөн найруулсан байна/.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь заалтад агуулагдах өргөн утга бүхий үг, хэллэг ойлгомжтой хэрэгжих нөхцөл болох Үндсэн хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хууль санаачлах хүрээ хязгаарыг нарийвчлан тусгаж, нэмэлт оруулах нь гүйцэтгэх эрх мэдэл болон Улсын Их Хурлын бүрэн эрх нь Ерөнхийлөгчийн бүрэн эрхтэй холилдохгүй зааглагдах, эрх мэдлийн хяналт, тэнцлийг бүрэн утгаар хангаж, 3 институтэд “дэмжлэг нөлөө үзүүлнэ” гэсэн зорилгоо хангах ач холбогдолтой юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч бүх ард түмнээс сонгогддог, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлдэг, зэвсэгт хүчний ерөнхий командлагч, хууль

санаачлах, Засгийн газарт чиглэл өгөх эрх эдэлдэг, Үндсэн хуулиас гадна бусад хуулиар Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг нэмэгдүүлэх боломж олгосон байдаг зэргээс үзвэл, Монгол Улсын Ерөнхийлөгчид бусад парламентын засаглалтай орны төрийн тэргүүнүүдээс илүү улс төрийн идэвхтэй байх, гүйцэтгэх эрх мэдэлд оролцох боломжийг нэмэгдүүлдэг. Иймд төрийн эрх мэдлийн хуваарилалтыг илүү тодорхой болгох, үндэсний эв нэгдлийг бататгах үүднээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг сонгодог парламентын тогтолцоотой орнуудын жишигт ойртуулах, төрийн тогтолцоонд эзлэх байр суурийг нь төгөлдөржүүлэх зарим шаардлага байгааг онцолсон байна (УИХ 2017, 22).

Ерөнхийлөгчийн дангаараа болон бусад институттэй хамтран хэрэгжүүлэх томилгооны бүрэн эрх 16 хуульд, дүрэм, журам батлахтай холбоотой бүрэн эрх 28 зүйлд буюу 17 хуульд, сонсох, танилцах, чиглэл өгөхтэй холбоотой бүрэн эрх 9 хуульд зохицуулагдсан байна. Дээрх заалтуудыг харахад тодорхой салбарын үйл ажиллагаанд Ерөнхийлөгчийн гүйцэтгэх үүрэг өргөн хүрээтэй харагдаж байгаа боловч санал санаачилга гаргах, чиглэл өгөх, өргөн мэдүүлэх зэрэг уян хатан байдлаар хэрэгжих, заавал хэрэгжүүлэхгүй байсан ч болох байдлаар хуульчилсан байна (Удирдлагын академи 2019, 71).

Ерөнхийлөгчийн үйл ажиллагаанд Парламентаас тавих хяналтын тухайд Үндсэн хуулийн 35 дугаар зүйлд *“Ерөнхийлөгчид УИХ-д ажлаа хариуцна”* гэж заасан бөгөөд энэ хариуцлагын хэлбэр нь *“Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн УИХ-аар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхын саналаар огируулна”* гэсэн зохицуулалттай. Монголын парламентын өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд Үндсэн хуулийн энэ заалтыг хэрэглэсэн тохиолдол гараагүй. Ерөнхийлөгч жил тутам үйл ажиллагааныхаа талаар УИХ-д танилцуулга бичиж хүргүүлдгийг хяналтын нэг хэлбэр гэж үзэж болно.

Төрийн засаглалын дээд институтүүдийг байгуулах журам, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч институтүүдийн тус тусын бүрэн эрхийн хэмжээ, хязгаар, хяналт, тэнцлийн тогтолцоо (a system of checks and balances)-ны үйлчлэлийн хүчинд төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч институтүүд зарим талаар нэг нэгнээсээ хамааралтай байж, харилцан нөлөөлөх, хянан тогтоох боломжтой байх ёстой. Тухайлбал, Ерөнхийлөгчийн хориг нь түүнээс парламентыг хянах, тогтоон барих, ингэснээрээ тэнцлийн хэрэгсэл болдог бол засгийн газарт итгэл үл үзүүлэхээ илэрхийлэх парламентын бүрэн эрх нь хууль тогтоох дээд байгууллагаас засгийн газраа хянан тогтоох арга болдог. Түүнчлэн ард түмнээс шууд сонгогдон бүрэн эрхээ хэрэгжүүлдэг Ерөнхийлөгчийн хувьд түүнд хариуцлага тооцох тодорхой субъект байдаггүй тул Ерөнхийлөгч Үндсэн хуулийг зөрчсөн талаар Үндсэн хуулийн цэцээс дүгнэлт гаргавал Улсын Их Хурал дийлэнх олонхоороо шийдвэрлэн огцруулах боломжийг Үндсэн хуулиар олгожээ.

IV. Судалгааны үр дүн

Тоон судалгааны шинжилгээ: Хууль санаачлах бүрэн эрх (ҮХ-ийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг). Монгол Улсад үе үеийн Ерөнхийлөгчид хууль санаачлах эрхийг идэвхтэй хэрэгжүүлж ирсэн билээ.

Хүснэгт 1. Ерөнхийлөгч нараас санаачилсан хуулийн төслүүдийн судалгаа

(Удирдлагын академи. 2019, 61)

	П.Очирбат	Н.Багабанди	Н.Энхбаяр	Ц.Элбэгдорж	Х.Баттулга
Хуулийн төсөл	11	16	11	24	
Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	1	14	8	18	7
Улсын Их Хурлын тогтоолын төсөл		8	3	5	1

Парламентын Бүгд Найрамдах Улсын төрийн тэргүүн хууль санаачлах бүрэн эрхийг төдийлөн хэрэгжүүлдэггүй талаар эрдэмтэн судлаачид үндэслэл, нотолгоо гаргаж, түүнчлэн судалгааны байгууллагаас хийсэн олон судалгааны үр дүн үүнийг нотолж байгааг тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Засгийн газарт чиглэл өгөх бүрэн эрх. Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т: “3) өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх. Энэ талаар Ерөнхийлөгч зарлиг гаргавал түүнд Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно” гэж заажээ. Монгол Улсын Ерөнхийлөгчид энэ бүрэн эрхийг идэвхтэй хэрэгжүүлж ирсэн болно.

Хүснэгт 2. Ерөнхийлөгчөөс Засгийн газарт чиглэл өгсөн зарлигуудын судалгаа

(Удирдлагын академи 2019, 52)

	П.Очирбат	Н.Багабанди	Н.Энхбаяр	Ц.Элбэгдорж	Х.Баттулга
ЗГ-т чиглэл өгсөн	16	15	3	35	1

Парламентын Бүгд Найрамдах Улсын төрийн тэргүүн ийм бүрэн эрхийг эдэлдэг эсэх асуудал маргаантай байдаг юм. Энэ асуудлаар хэд хэдэн судалгаа хийгдсэн байдаг. Тухайлбал, Улсын Их Хурлын судалгааны төв парламентын бүгд найрамдах 11 улсын (Болгар, Финланд, Серби, Монтенегро, Хорват, Исланд, Сингапур, Словак, Турк, Македон, Киргиз) хүрээнд харьцуулахад Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх эрх эдгээр 11 улсын Үндсэн хуульд тусгагдаагүй байна (УИХ 2017, 198).

Улсын Их Хуралд болон ард түмэндээ хандан илгээлт гаргаж, чуулганд өөрийн тааллаар оролцон улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлж, саналаа оруулах бүрэн эрх.

Хүснэгт 3. Ерөнхийлөгчийн хэм хэмжээ тогтоосон зарлигуудын судалгаа

(Удирдлагын академи 2019, 59)

	П.Очирбат	Н.Багабанди	Н.Энхбаяр	Ц.Элбэгдорж	Х.Баттулга
Бүх нийтийг уриалсан	5	5	7	11	3
Дүрэм, журам баталсан	16	21	9	12	7

Бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр батлах, бүтэц батлах, эрх олгох	2	1	2	3	1
---	---	---	---	---	---

Энэхүү судалгааг гаргахдаа legalinfo.mn, president.mn, “Монгол Улсын Ерөнхийлөгч-25 жил (он дарааллын товчоон 1990.09-2015.10)”, “Монгол Улсын Ерөнхийлөгч (он дарааллын товчоон 2009-2016)” зэрэг эх сурвалжийн зарим тоон мэдээллийг ашигласан болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн дүн шинжилгээ. *Ерөнхийлөгчийн хориг*. Монгол Улсын шинэ Үндсэн хуулиар 1992 онд Ерөнхийлөгчийн институтийг бий болгосноос хойш Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өөрийн бүрэн эрхийн хүрээнд 1993-2019 оны хооронд 27 жилийн хугацаанд нийт 61 удаа хориг тавьсны 23 нь хууль тогтоомжид бүхэлд нь, 38 нь хэсэгчлэн тавьсан хориг 48 байна.

Хүснэгт 4. Ерөнхийлөгчийн хориг (1993-2019) (Удирдлагын академи 2019, 48)

№	Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрс	Бүрэн эрхийн хугацаа	Бүхэлд нь тавьсан хориг	Хэсэгчлэн тавьсан хориг	Хүлээн авсан Эсэх		Хоригийн нийт тоо, хүлээн авсан хувь
					Тийм	Үгүй	
1	Пунсалмаагийн Очирбат	1993-1997	2	5	3	4	7 (42 хувь)
2	Нацагийн Багабанди	1997-2001	6	9	11	4	15 (73 хувь)
3	Нацагийн Багабанди	2001-2005	4	11	9	6	15 (66 хувь)
4	Намбарын Энхбаяр	2005-2009	3	6	7	2	9 (78 хувь)
5	Цахиагийн Элбэгдорж	2009-2013	2	3	4	1	5 (80 хувь)
6	Цахиагийн Элбэгдорж	2013-2017	3	4	6	1	
7	Халтмаагийн Баттулга	2017-2021	2	2	1	3	4 (25 хувь)

Нийт хоригийн 2/3-г хүлээн зөвшөөрч, үлдэх хэсэг буюу 1/3-г хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн тогтоол гарсан байна. Ерөнхийлөгчөөс тавьсан нийт хоригийн агуулгыг авч үзвэл Улсын Их Хурал нь төрийн алба, Засгийн газар, Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, төрийн байгуулалт, улс төрийн нам, татвар, шүүх эрх мэдлийн үйл ажиллагаатай холбоотой (прокурорын байгууллага, шийдвэр гүйцэтгэлийг оруулав) хууль тогтоомжуудад хориг тавьсан байна. Хүлээн зөвшөөрөөгүй гэсэн хариу өгсөн тогтоолын хувьд төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэв, хангамж, Засгийн газрын бүтэц, гүйцэтгэх ажлын тухай, Үндсэн хуульд оруулсан нэмэлт,

өөрчлөлтийн тухай, шүүх эрх мэдлийн үйл ажиллагаанд оруулсан өөрчлөлт, улс төрийн нам, төсөв, сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт зэрэг өөрчлөлттэй холбоотой асуудлууд байна.

Чанарын судалгааны шинжилгээ: 1992 оноос хойш бүрэн эрхээ дуусгасан хоёрхон Засгийн газар байсан бөгөөд бусад Засгийн газар хугацаанаас өмнө огцорч байжээ. Нэг парламентын бүрэн эрхийн хугацаанд дөрвөн Засгийн газар солигдож байсан тохиолдол ч гарч байв. Иймд төрийн тогтолцооны энэхүү доголдол, тэнцвэргүй, хэврэг байдлыг арилгах цорын ганц зам нь парламентын засаглалтай улсын хувьд парламент болон засгийн газрын хооронд зөрчилдөөн үүссэн тохиолдолд ерөнхий сайдын саналаар парламентыг тараах бодит бүрэн эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгчид олгох нь чухал юм.

V. Дүгнэлт

Монгол Улсын хувьд Үндсэн хуулийг анхлан боловсруулагчдын хүсэл зоригийг эрхэмлэн, Ерөнхийлөгчийн ёслол, бэлгэдлийн шинжтэй эрх мэдэл хэрэгжүүлэх Үндсэн хуулийн үзэл санааг баримтлах нь зүйтэй юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч бүх ард түмнээс сонгогддог, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлдэг, зэвсэгт хүчний ерөнхий командлагч, хууль санаачлах, Засгийн газарт чиглэл өгөх эрх эдэлдэг, Үндсэн хуулиас гадна бусад хуулиар Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг нэмэгдүүлэх боломж олгосон байдаг зэргээс үзвэл, Монгол Улсын Ерөнхийлөгчид бусад парламентын засаглалтай орны төрийн тэргүүнүүдээс илүү улс төрийн идэвхтэй байх, гүйцэтгэх эрх мэдэлд оролцох боломжийг нэмэгдүүлсэн.

Парламент болон Засгийн газрын хоорондох зөрчил, маргаантай холбогдож Засгийн газарт Улсын Их Хурал итгэл үзүүлэхээс татгалзвал Монгол Улсын Ерөнхийлөгчид парламентыг тараах бүрэн эрх илт дутагдаж байна. Иймд парламентын засаглалтай бусад орны жишгээр Ерөнхий сайдын саналаар парламентыг тараах бүрэн эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгчид олгох шаардлагатай байна. Үүний үр дүнд хяналт, тэнцлийн зарчим хэрэгжиж, төрийн тогтолцоо тогтворжино.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь заалтад агуулагдах өргөн утга бүхий үг, хэллэг ойлгомжтой хэрэгжих нөхцөл болох Үндсэн хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хууль санаачлах хүрээ хязгаарыг нарийвчлан тусгаж, нэмэлт оруулах нь гүйцэтгэх эрх мэдэл болон Улсын Их Хурлын бүрэн эрх нь Ерөнхийлөгчийн бүрэн эрхтэй холилдохгүй зааглагдах, эрх мэдлийн хяналт, тэнцлийг бүрэн утгаар хангаж, 3 институтэд “дэмжлэг нөлөө үзүүлнэ” гэсэн зорилгоо хангах ач холбогдолтой юм.

Төрийн тэргүүн төрийн байгууллагуудын системд дээд байр суурь эзэлж буй албан тушаалтан буюу институт, улс төрийн тогтолцоонд чухал байр суурь эзэлж, төрийн хууль ёсны үйл ажиллагаа, улс төрийн хүчнүүдийн хоорондын харилцаа, үндэсний эв нэгдлийн ашиг сонирхлын хэрэгжилтэд онцгой үүрэгтэй байх, улс орны дотоодод болон гадаадад төрийн дээд төлөөлөл болохын зэрэгцээ улс үндэстний эв нэгдлийн билэг тэмдэг болдог. Монгол Улсын Үндсэн хуульд

заасны дагуу төрийн тэргүүн төрийн гадаад, дотоод тусгаар байдлын баталгаа, улс орны тусгаар тогтнол, бие даасан байдлын илэрхийлэл болдог. Үндсэн хууль болон бусад хууль үйлчилж эхэлсэн практикаас харахад Ерөнхийлөгч төрийн тэргүүн гэсэн статусаар албан ёсны шийдвэр гаргах тогтолцоо байхгүй байгаа нь тодорхой харагдаж байна.

Монгол Улсын төрийн тэргүүн, Ерөнхийлөгч бол төрийн дээд албан тушаалтан хүн төдий биш Монгол Улсын, ард түмний эв нэгдлийн илэрхийлэл, тусгаар тогтнолын баталгаа, төр улсын төлөөлөл гэдэг утгаар уламжлал, шинэчлэлийг хослуулан хөгжүүлэн төлөвшүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

Төрийн тэргүүний төрийн дээд төлөөллийн бүрэн эрх нь Ерөнхийлөгчид хуулиар олгосон бүрэн эрхтэй аль болох дүйж, түүнийгээ хэрэгжүүлэх тогтолцоо нь нэн тодорхой байх явдал, ялангуяа одоогийн бий болоод байгаа улс төрийн нөхцөл байдалд Ерөнхийлөгч хуулиар өөрт олгогдсон нийгмийн үүргээ гүйцэтгэхэд нь нэн чухал ач холбогдолтой хэмээн үзэж дараахь саналыг дэвшүүлж байна.

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг сонгодог парламентын тогтолцоотой орнуудын жишигт нийцүүлэх, төрийн тогтолцоонд түүний эзлэх байр суурийг нь төгөлдөржүүлэх;
- Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан агуулгад нийцүүлж, Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхийн нэгдмэл байдлыг хангаж, Ерөнхийлөгчийн “бусад тодорхой бүрэн эрх”-ийг Үндсэн хуульд заасан үндсэн бүрэн эрхийн хүрээнд байх агуулгаар нарийвчлан хуульчлах;
- Ерөнхийлөгч ба төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч бусад байгууллагын үйл ажиллагаа, эрх мэдлийн уялдаа, зохилцолдоог сайжруулах чиглэлээр холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах;
- Ерөнхийлөгчийг хуульт ёсыг дээдлэн оногдсон эрхээ эдэлж, эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийн зарчмыг хэрэгжүүлж, ард түмнийхээ эрх ашгийг нэн тэргүүнд тавьж ажиллах үүрэг, хариуцлагын эрх зүйн зохицуулалтыг Ерөнхийлөгчийн тухай хуульд тусгах;
- Ерөнхийлөгч төрийн уламжлалттай зохицож, шашин, соёлыг нэгтгэж, төрийн тэргүүний дүр төрх, имижийг бүрдүүлж Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийг дагаж мөрдөж ажиллах;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь заалтад агуулагдах өргөн утга бүхий үг, хэллэг ойлгомжтой хэрэгжих нөхцөл болох Үндсэн хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хууль санаачлах хүрээ хязгаарыг нарийвчлан тусгаж, нэмэлт оруулах
- Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхийг органик хууль болон бусад хуулиар тодорхой болгож нарийвчлах;
- Төрийн эрх мэдлийн хуваарилалтыг илүү тодорхой болгох, үндэсний эв нэгдлийг бататгах;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийг Парламентын засаглалыг бэхжүүлэх, төрийн тэргүүний статус талаас нь хууль, эрх зүйн шинэчлэл хийх;
- Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг өргөжүүлэхгүйгээр төрийн эрх мэдлийн хуваарилалтыг хангахад зуучлагч, хяналт тэнцлийг тэнцвэржүүлэх чиг үүрэгтэй байхаар авч үзэх;
- Ерөнхийлөгчийн үндэсний аюулгүй байдал, эв нэгдэл, батлан хамгаалах, нийгэм, соёл, шинжлэх ухааны салбарын эрх, үүргийг багцлах, өөрчилж сайжруулах;

Ашигласан материал

- Ганхуяг Д. 2004. *Хошуучлагчийн улс төрийн имиж, түүнийг бүрдүүлэхүй*. Уб.
- Гангабаатар Д. 2016. *Үндсэн хуулийн эрх зүй*. Уб. 2016. *Үндсэн хуулийн эрх зүй*.
- Амарсанаа Ж. 2009. *Ардчилсан эрх зүйт ёс*. ХЗҮХ, ШУА-ийн ФСЭЗХ, Адмон ХХК. Уб.
- Лүндэндорж Н. 2010. *Шилжилтийн үеийн улс төр, эрх зүйн асуудал*. Уб.
- Чимид Б. 2008. *Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал*. Уб.
- ЕТГ. 1993. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн танилцуулга, чуулганы протокол,” Уб., 8 дахь тал
- ХЗҮХ. 2021. “Монгол Улсын Ерөнхийлөгчид бүрэн эрх олгосон холбогдох хуулийн зохицуулалтын судалгаа.” Уб.
- Монгол Улсын Үндсэн хууль. 1992. Төрийн мэдээлэл эмхэтгэл, №1 . Уб.
- Төгөлдөр Я. 2018. “Монгол Улсын төрийн тогтолцоон дахь Ерөнхийлөгчийн институтийн байр суурь эрх мэдлийн хэрэгжилтийн шинжилгээ”, Монгол Улсын Төрийн байгуулал дахь засаглалын инстутын талаарх судалгаа.” Судалгааны эмхэтгэл, , Уб., 39 дахь тал
- УТБА. 2021. “Ерөнхийлөгчийн институци. ” *Шинэ толь сэтгүүл*, 29 дахь тал
- Konrad Adenauer stiftung. 2022. *Улс төр ба нийгэм (дээж мэдлэг)*. Уб., КАС.
- Конрад Аденауэрын сан. 2022. *Улс төр ба нийгэм (дээж мэдлэг)*. Уб., КАС.
- Удирдлагын академи. 2019. *Монгол Улсын төрийн тогтолцоон дахь Ерөнхийлөгчийн байр суурь, бүрэн эрхийн шинжилгээ*. Судалгааны тайлан №018, Уб., УА, ix.
- ХЗҮХ. 2021. *Ерөнхийлөгчийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ*. Судалгааны тайлан. , Убвь Хууль зүйн үндэсний хүрээлэн, 13 дахь тал
- ХЗҮХ. 2020. “Монгол Улсын Үндсэн хууль дахь Ерөнхийлөгчийн институтийн зарим нэр томъёоны судалгаа.” *Хууль дээдлэх ёс сэтгүүл (Хууль зүйн үндэсний хүрээлэн)* (76): 191 дэх тал
- Конрад-Аденауэр-Сан. 2018. *Монгол Улсын төрийн байгуулал дахь засаглалын институтийн талаарх судалгаа*. КАС, Мөнхийн үсэг ХХК, Уб.
- Non-Executive Presidents in Parliamentary Democracies*. <https://constitutionnet.org/primers>.
- Zaznaev Oleg. 2014. “Measuring Presidential Power: A Review of Contemporary Methods.” *Mediterranean Journal of Social Sciences*,.
2021. “France, Germany & the United States: The Risk of a Dictatorship “lawfully producing a dictator”, ” *lepetitjuriste*. 1 20 . <https://www.lepetitjuriste.fr/france-germany-the-united-states-the-risk-of-a-dictatorship/>.
- “The European Consortium for Political Research (ECPR).” www.ecpr.eu.
2021. *Studylecturenotes.com*. 01 18. <http://studylecturenotes.com/powers-functions-of-french-president-in-french-constitution>.
2021. *Presidential Legislative Powers*. 01 18. <https://constitutionnet.org/primers> . thelocal.fr. <https://www.thelocal.fr/20120503/3247>.
- n.d. *Presidential Legislative Powers*. <https://constitutionnet.org/primers>.
- УИХ. 2017. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар

- зөвлөлдөх санал асуулга явуулах сэдвийн танилцуулга. Уб., 22 дахь тал
- Удирдлагын академи. 2019. *Монгол Улсын Төрийн тогтолцоон дахь Ерөнхийлөгчийн байр суурь: Бүрэн эрхийн шинжилгээ*. Удирдлагын академийн судалгааны тайлан., Уб., УА, Мөнхийн үсэг ХХК. 71 дахь тал
- Удирдлагын академи. 2019. *Монгол Улсын төрийн тогтолцоон дахь Ерөнхийлөгчийн байр суурь: бүрэн эрхийн шинжилгээ судалгааны тайлан*. УА, Уб., 61 дахь тал
- Удирдлагын академи. 2019. “Монгол Улсын төрийн тогтолцоон дахь Ерөнхийлөгчийн байр суурь: бүрэн эрхийн шинжилгээ.” Судалгааны тайлан., Уб., 52 дахь тал
- УИХ. 2017. *Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлтэй холбоотой судалгаа, мэдээлэл, лавлагаа*. Уб., УИХТГ, 198 дахь тал
- Удирдлагын академи. 2019. “Монгол Улсын төрийн тогтолцоон дахь Ерөнхийлөгчийн байр суурь: бүрэн эрхийн шинжилгээ судалгааны тайлан.” Уб., 59 дахь тал
- Удирдлагын академи. 2019. Монгол Улсын төрийн тогтолцоон дахь Ерөнхийлөгчийн байр суурь: бүрэн эрхийн шинжилгээ судалгааны тайлан. Уб., 48 дахь тал

Санхүүжилт. Боловсрол, Шинжлэх ухааны яамны “Улс төрийн харилцаанд улс төрийн хошуучлалын гүйцэтгэж буй үүрэг, үр нөлөө” сэдэвт суурь судалгаан төслийн хүрээнд уялдуулж энэхүү эрдэм шинжилгээний өгүүллийг бичсэн болно.

Талархал. ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрдэм шинжилгээний ажилтнуудын дунд эрдэм шинжилгээний өгүүллийг хэлэлцүүлж сэдвээ нарийвчилан томъёолж, судалгааны хамрах цар хүрээгээ хумиж тодорхой болгож, судалгааны чиг баримжаагаа олсон. Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэл бичихэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч, чиглүүлсэн ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрхлэгч, ЭШТА, доктор (Ph.D) О.Хатанболд, эрдэм шинжилгээний дэд ажилтан, докторант А.Хишигдаваа нарт талархал илэрхийлье.